



ВЭМР

ДЭЛХИЙН ЧАНАРЫГ
МОНГОЛД ҮЙЛДВЭРЛЭВ



ProCube

Барилгын дотор цахилгаан
хангамжийн хуваарилах самбар

ЧАНАРЫГ ЭРХЭМЛЭН
МОНГОЛДОО ҮЙЛДВЭРЛЭЖ

ХАМГИЙН ХЯМДААР
ДОТООДДОО нийлүүлнэ.



4-11

ХУУДАС

- Компанийн тухай
- Дотор хангамжийн хуваарилах самбар
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн онцлог
- Зориулалт хамрах хүрээ

12-89

ХУУДАС

- Барилгын дотор цахилгаан хангамжийн бүх төрлийн хуваарилах самбарын цогц шийдэл

90-97

ХУУДАС

- Дамжуулагч шин
- Автомат тоноглолын төрөл
- Модуль хэмжээст
- Кабель хамгаалалт

98-109

ХУУДАС

- Аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Ачиж тээвэрлэх зөвлөмж
- Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ
- Холбоо барих



КОМПАНИЙН ТУХАЙ

“Багануур Цахилгаан Механикийн Үйлдвэр” ХХК нь эрчим хүчний тоног төхөөрөмжийн зохион бүтээлт, үйлдвэрлэл, худалдааны салбарт 2010 оноос хойш өнөөг хүртэл 12 жилийн туршлагадаа үндэслэн эрчим хүчний салбарын хөгжил, дэлхийн чиг хандлагад нийцүүлэн импортыг орлох эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж буй дотоодын 100%-ийн хөрөнгө оруулалттай үндэсний үйлдвэрлэгч компани юм.

Бид “Дэлхийн Чанарыг Монголд Үйлдвэрлэв” гэсэн алсын хараан дор цахилгаан механикийн үйлдвэрлэлийн чиглэлээр үндэсний үйлдвэрлэгч

болох чин хүсэл эрмэлзэлтэй 200 гаруй мэргэшсэн, чадварлаг, залуу хамт олныг бүрдүүлэн дэлхийн жишигт нийцсэн техник, технологи бүхий тоног төхөөрөмжүүдийг эх орондоо нутагшуулан дэлхийн хөгжилтэй мөр зэрэгцэн үйлдвэрлэл явуулж байна.

Манай үйлдвэр эрчим хүч, барилга, уул уурхай болон бусад салбарын хэрэглэгчидтэй хамтран ажиллаж, 6 ангиллын 300 гаруй нэр төрлийн цахилгаан эрчим хүчний тоног төхөөрөмжүүд болон захиалгат нимгэн төмөр хийцлэлийн бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нийлүүлэн ажиллаж байна.

ДОТООДЫН ҮЙЛДВЭРИЙН ОНЦЛОГ

Бид харилцагч үйлчлүүлэгч нартаа үйлдвэрлэлийн давуу талаа ашиглан төслийн талбай дээр нийлүүлэлтийн дараах бүх төрлийн үйлчилгээ, сургалт, зөвлөгөө үзүүлэн хамтран ажилладагт манай үйлдвэрийн онцлог оршино.

- Үйлдвэрлэл нь монгол улсдаа байрлаж буй давуу талаа ашиглан харилцагч нартаа туслан хамтран ажиллана.
- Импортын болон засвар үйлчилгээний зардлыг бууруулан харилцагч нартаа эдийн засгийн бодит хэмнэлтийг үзүүлнэ.
- Төсөл эхлэхээс дуустал хамтран ажиллаж, харилцагч нарт тулгарсан асуудлыг хамтран шийдвэрлэж шуурхай үйлчилнэ.
- Шаардлагатай нөхцөлд захиалгын өөрчлөлт,

шийдлийг тусгаж чанарын өндөр түвшинд үйлдвэрлэн нийлүүлнэ.

- Төслийн төлөвлөсөн хугацаанд бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангаж харилцагч нарынхаа ажлын бүтээмжийг дэмжин, цаг хугацаа болоод урсгал зардлагыг хэмнэхэд тусална.
- Баталгаат хугацааны үзлэг, борлуулалтын дараах сервис үйлчилгээг үзүүлэн хамтын ажиллагааг урт хугацаанд тогтвортой барьж ажиллана.

PROCUBE БРЭНДИЙН ДОТОР ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОНЦЛОГ БОЛОН БАТАЛГАА

БНМЦҮ ХХК нь дэлхийн цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэгчдийн туршлага, эрчим хүчний салбарын ирээдүйн хөгжил, түгээх сүлжээний инженерүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн дотор цахилгаан хангамжийн самбаруудыг хамгийн оновчтой шийдлээр зохион бүтээж ProCube брэндийг бий болгосон.

ProCube брэндийн самбарууд нь дифференциал болон энгийн автомат, рубильник, автомат сэлгэн

залгагч, цэнэг шавхагч, гал хамгаалагч, ачаалал таслагч, хамгаалалтын реле, дагалдах тоноглол болон холболт хэлхээнүүдийг багтаасан модуль хэмжээст самбар юм.

Бид бүх төрлийн барилгын интерьер дизайнд тохируулж өнгө, материалын сонголт, ил болон далд суурилуулах олон төрлийн загварыг захиалагчид санал болгож хэрэгцээ шаардлагад нь нийцүүлэн зохион бүтээж үйлдвэрлэдгээрээ онцлогтой.

ProCube загварын самбарууд нь Шнайдер Электрик болон Декрафт брэндийн автомат таслуур, автомат сэлгэн залгагчаар тоноглож, ССА шин болон галын А үнэлгээтэй кабелиар холболт хийж зэвэрдэггүй төмөр листээр хайрцаг болон модулийн хаалтыг

үйлдвэрлэн өндөр хүчдэлийн туршилтын лабораторид туршиж, бүхий л шат дамжлагыг чанарын хяналтаар баталгаажуулан үйлдвэрт ашиглалтад оруулдаг.

- Ус, тоос шорооноос бүрэн хамгаалах IP43-54 хамгаалалтын зэргийг хангасан
- Олон улсын стандарт шаардлагад нийцсэн
- Аюулгүй ажиллагаа найдвартай байдлыг бүрэн хангасан
- Ашиглалтын хугацаа урт

Таны барилгын цахилгаан эрчим хүч тогтмол хэвийн ажиллагаатай байх нь манай үйлдвэрийн үнэт зүйл учраас бидний бүх үйлдвэрлэл таны барилгын цахилгааны найдвартай, аюулгүй ажиллагааг хангахад зориулагдсан.



**БАРИЛГЫН ДОТОР ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ДАРААХ
ШААРДЛАГЫГ БИД ШИЙДВЭРЛЭДЭГ.**

Эрчим хүчний салбарын шинжээчид дотор хангамжийн зориулалттай хуваарилах самбарууд нь бүхэлдээ аюулгүй ажиллагааг хангах, дэлхийн жишигт нийцэх, дэвшилтэт бөгөөд ухаалаг бүтээгдэхүүнийг онцолдог.

Дэлхий даяар барилгын аюулгүй нөхцөл, найдвартай байдлыг хангах үүднээс цахилгаан эрчим хүчний суурилуулалтад өндөр шаардлага тавьдаг бөгөөд ОУЦТХ болон олон улсын стандартад бүх хүчний хэлхээн хамгаалалтын дамжуулагчийг оруулахыг шаарддаг.

Ихэнх улс оронд цахилгаан тоноглол нь цахилгааны угсралтын улсын эрх бүхий байгууллага эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн хувийн хэвшлийн байгууллагаас тогтоосон стандартад нийцсэн байх ёстой бөгөөд одоогоор аюулгүй ажиллагааны IEC 61439-1, IEC 61439-2 стандарт нь дэлхий даяар түгээмэл ашиглаж байгаа нь цахилгаан тоноглолын олон улсын дүрмийн үндэс нь болж байна.

БНЦМУ ХХК нь эрчим хүчний зохицуулах хороо болон шинжээчдийн хүлээн зөвшөөрдөг олон улсын чанарын стандарт, аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан цахилгаан тоноглол болон туслах түүхий эд материал, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн ажиллаж дээрх шаардлагуудыг хангаж байна.

ProCube брэндийн самбарууд нь дараах хялбар шийдлүүдийг бүрдүүлсэн зах зээлийн тэргүүлэгч бүтээгдэхүүний нэг юм.



Чанарын баталгаа - Насан туршийн хэрэглээ



Интерьер дизайнд нийцсэн – Тав тухтай орчин



Олон улсын стандартыг хангасан – Аюулгүй байдал, найдвартай ажиллагаа



Холболт, суурилуулалтыг хялбаршуулсан шийдэлтэй



Загвар, өнгө үзэмжийг хэрэглэгч сонгох боломжтой



Доторх тоноглолууд нь чанартай бөгөөд найдвартай



Туршилтаар баталгаажиж үйлдвэрт ашиглалтад оруулсан



Галын эрсдэлийн үнэлгээтэй



Хэрэглэгчийн сэтгэл ханамжтай байдал нь хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ

СЭТГЭЛ ХАНАМЖ – УРТ ХУГАЦААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА




БАРИЛГЫН ХУВААРИЛАХ САМБАРЫН ЗОРИУЛАЛТ БА ХАМРАХ ХҮРЭЭ

ProCube брэндийн барилгын хуваарилах самбарууд нь чанарын өндөр түвшинд үйлдвэрлэдэг аюулгүй байдлыг дээд зэргээр хангасан барилгын дотор цахилгаан хангамжийн зориулалттай бүтээгдэхүүн юм.

Тухайлбал хэрэглэгч таны барилгад оролтын ерөнхий самбар, ерөнхий хуваарилах самбар, автомат сэлгэн залгагчтай самбар, гэрэлтүүлгийн самбар, давхрын нэгдсэн самбар болон айлын самбар гэсэн цогц шийдлийг бүрдүүлж өгнө.


ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЛЭЭ



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭРЭГЛЭЭ



АХУЙН ХЭРЭГЛЭЭ





KZ.Q.00.0579

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар: MC 11/QMS 140 22

“БАГАНУУР ЦАХИЛГААН МЕХАНИКИЙН ҮЙЛДВЭР” ХХК

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Багануур дүүрэг,
3-р хороо, Уурхайчдын гудамж-22

үйл ажиллагаандаа менежментийн тогтолцоог

ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО

ISO 9001:2015

стандартын шаардлагын дагуу нэвтрүүлснийг
баталгаажуулан гэрчилгээ олгов.

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

- Гадна цахилгаан хангамжийн зохион бүтээлт, үйлдвэрлэл, угсралт
- Дотор цахилгаан хангамжийн зохион бүтээлт, үйлдвэрлэл, угсралт
- Уул уурхайн цахилгаан хангамж зохион бүтээлт, үйлдвэрлэл, угсралт
- Сэргээгдэх эрчим хүч цахилгаан хангамжийн үйлдвэрлэл, угсралт
- Нимгэн төмөр хийцлэлийн зохион бүтээлт үйлдвэрлэл, худалдаа
- 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил

Анх олгосон он: 2019.12.26 Олгосон огноо: 2022.04.15
Хүчинтэй хугацаа: 2025.04.14




МОНСЕРТФ ХХК
Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, 7-р хороолол,
Алтайн гудамж 281, Хоймор оффис, 15 давхар, 1505 тоот
Утас: 70115522, E-mail: info@moncertf.mn



Бид 300 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд таниулан найдвартай хамтрагч, хариуцлагатай нийлүүлэгч гэдгээ батлан чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2015 стандартыг 2019 оноос амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна.



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ

УБД2278

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

Баталгаажуулалтын байгууллагын нэр

Аж ахуйн нэгж, байгууллага/иргэн:

Нэр: Багануурын цахилгаан механикийн үйлдвэр ХХК
Регистр: 4551958
Утас/Факс: 70210215
И-мэйл: info@emi-baganuur.mn
Хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Уурхайчин гудамж, Үйлдвэрийн хэсэг

Энэхүү гэрчилгээг олгоход үндэслэсэн баримт, бичгүүд:

1. Сорилтын дүнгийн дугаар, огноо: 22-0516 2022-05-16
2. Сорилт хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн нэр: Багануурын зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Өндөр хүчдэл туршилтын лаборатори
3. Удирдлагын тогтолцооны нэр, гэрчилгээний дугаар, олгосон байгууллагын нэр:
Бүтээгдэхүүний баталгаажуулалтын зөвлөлийн 2022.07.06-ны өдрийн хурлын 06/22 тоот тэмдэглэл

Бүтээгдэхүүн үйлчилгээний тодорхойлолт:

1. Иж бүрэн трансформаторын дэд өртөө, олон нийтийн болон үйлдвэрийн барилгын хуваарилах самбар, орон сууцны барилгын цахилгаан самбар	8504	MNS 5643:2006, MNS 5644:2006, MNS 5834:2008
--	------	---

Дээрхи бүтээгдэхүүн үйлчилгээ нь холбогдох стандарт, норматив техникийн баримт бичиг (НТББ)-ийн шаардлагыг хангаж байгаа тул энэхүү ГЭРЧИЛГЭЭ-г олгов.



В.ГАНЗОРИГ
Эрх бүхий албан тушаалтан



А.НЭРГҮЙСЭЙХАН
Инжээч/эксперт



2022-07-06
Олгосон огноо
000652
2025-07-06

СТАНДАРТ
ProCube брэндийн барилгын хуваарилах самбарууд нь

Монгол улсын: **MNS 5643:2006**
MNS 5644:2006
MNS 5834:2008

Олон улсын: **IEC 61439-1**
IEC 61439-2

стандарт шаардлагуудыг бүрэн хангаж тохирлын гэрчилгээгээр баталгаажсан бүтээгдэхүүнүүд юм.



ProCube.DI

ЕРӨНХИЙ
ОРУУЛГЫН САМБАР

ProCube.DL

ЕРӨНХИЙ
ХУВААРИЛАХ САМБАР

ProCube.DM

ХУВААРИЛАХ
САМБАР

ProCube.DA

АВТОМАТ СЭЛГЭН
ЗАЛГАГЧТАЙ САМБАР

ProCube.DS

ГЭРЭЛТҮҮЛГИЙН
САМБАР

ProCube.WH

ДАВХРЫН
ТООЛУУРЫН САМБАР

ProCube.HB


АЙЛЫН
ЦАХИЛГААНЫ САМБАР

ProCube.DI

Ерөнхий оруулгын самбар



БҮТЭЦ



**WE BUILD
YOUR SAFETY**



ProCube.DI /PC.DI/ загварын 0.4кВ-ийн оруулгын ерөнхий самбар нь олон улсын IEC 61439-1, IEC 61439-2, Монгол улсын MNS 5834:2008 стандартуудын шаардлагад бүрэн нийцүүлэн чанарын өндөр түвшинд дараах төрлүүдээр үйлдвэрлэдэг аюулгүй байдлыг дээд зэргээр хангасан бүтээгдэхүүн юм.

- 1. Хуурай салгуур, гал хамгаалагч
- 2. Хуурай салгуур, автомат

Ерөнхий оруулгын самбар нь IP54 хамгаалалтын зэргийг хангасан бөгөөд хайрцагт нэмэлтээр хэмжих хэрэгсэл, цэнэг шавхагч суулгаж болохоос гадна хэмжүүр тоолуурын хэлхээний гүйдлийн трансформаторыг тус тусад нь холбох кабель утсыг цогцоор шийдэж өгсөн.

Техникийн үзүүлэлт


Ерөнхий	Бүтээгдэхүүний төрөл	Барилгын дотор хангамжийн ерөнхий оруулгын самбар
	Бүрэлдэхүүн хэсгийн төрөл	ProCube
	Бүтээгдэхүүний богино нэр	PC.DI
	Бүтээгдэхүүний ашиглах хүрээ	Бүх төрлийн барилга байгууламж, үйлдвэр
	Сэлгэн залгалтын төрөл	Гар
	Оруулгын төрөл	Кабелийн оруулгатай
	Гаргалгын төрөл	Кабелийн гаргалгатай
	Суурьлуулалтын төрөл	Шалан дээр
	Ашиглах зориулалт	Суурин
	Хамгаалалтын зэрэглэл	IP54
	Хаалганы төрөл	Шилэн / Төмөр
Үзүүлэлт	Сүлжээний фазын тоо	3 фаз
	Давтамж	50hz
	U хэвийн хүчдэл	400V
	I Нам хүчдэлийн хэвийн A	250Ax2, 400Ax2, 630Ax2
	Ici богино залгааны таслах гүйдлийн хязгаар	25-40кА
	Автомат таслуурын төрөл	MCCB
	Зузаан	500мм
	Өргөн	910мм, 960мм
	Өндөр	1600мм, 1800мм, 2000мм
	Өнгө	RAL 9003 /сонголттой/
	Материал	1-3мм цайрдсан ган лист
Нэмэлт	Цоожны систем	2 цэгийн цоожлолт
	Хаалга онгойх градус	180°
	Стандарт	ISO9001:2015, MNS 5834:2008
	Сертификат	ТГ№УБД0001631
	Ашиглалтын орчны агаарын температур	-50*С...+50*С
	Харьцангуй чийгшил	0...95%
	Хадгалах орчны агаарын температур	-40*С...+50*С

PC.DI бүтээгдэхүүний онцлог тал


- ССА буюу хөнгөрүүлсэн зэс шин дамжуулагчтай
- Галд тэсвэртэй кабель утсаар монтажилсан
- Хэмжүүрийн хэсгийг гадны нөлөөллөөс хамгаалсан шийдэлтэй
- Самбарыг 1-3мм зузаантай цайрдсан ган төмөр листээр үйлдвэрлэсэн
- Гүйдэл хөндийрүүлэх чадвартай, хүний биед хоргүй хуурай будгаар бүрсэн
- 2 цэгийн цоожны системээр түгжигддэг хаалгатай
- Ашиглалт болон үйлчилгээ хийх үед аюулгүй байдлыг хангаж 180° дэлгэгддэг хаалгатай
- Интерьер дизайнд тохирсон өнгө загварын сонголттой

Хэмжээст зураг

РУБИЛЬНИК ГАЛ ХАМГААЛАГЧ




РУБИЛЬНИК АВТОМАТ




Бүтээгдэхүүний төрөл	Өндөр (H)	Өргөн (W)	Зузаан (D)
PC.DI-250-C	1600	910	500
PC.DI-400-C	1800	910	500
PC.DI-630-C	2000	960	500

Схем зураг

РУБИЛЬНИК ГАЛ ХАМГААЛАГЧ



РУБИЛЬНИК АВТОМАТТАЙ




ProCube.DL

Ерөнхий хуваарилах самбар



БҮТЭЦ



**WE BUILD
YOUR SAFETY**



ProCube.DL /PC.DL/ загвар нь модуль системийн аргаар оруулгын ерөнхий самбар болон ерөнхий хуваарилах самбаруудын зориулалтаар угсрагддаг бөгөөд шугамын холболтын төрлүүд нь босоо болон хөндлөн гэсэн 2 төрлөөр хэлхээнд холбогддог.

Барилгын ерөнхий хуваарилах самбарын гол давуу тал нь гаралтын сувгийн кабелийн канал хэсгийг зааглаж өгсөн бөгөөд энэ нь автомат таслуурын гаралтыг клем тоноглолоор дамжуулан холболт хийхээр зохион бүтээж угсралтын компанийн ажлыг хялбарчилж өгсөн. Мөн нэмэлтээр хэмжих хэрэгслийг суулгаж болохоос гадна хэмжүүр тоолуурын хэлхээний гүйдлийн трансформаторыг тус тусад нь холбож цогцоор нь шийдвэрлэх боломжтой IP54 хамгаалалтын зэрэгтэй онцлох бүтээгдэхүүн юм.

Техникийн үзүүлэлт

Ерөнхий	Бүтээгдэхүүний төрөл	Барилгын дотор хангамжийн ерөнхий хувиарлах самбар
	Бүрэлдэхүүн хэсгийн төрөл	ProCube
	Бүтээгдэхүүний богино нэр	PC.DL
	Бүтээгдэхүүний ашиглах хүрээ	Бүх төрлийн барилга байгууламж, үйлдвэр
	Оруулгын төрөл	Кабелийн оруулгатай
	Гаргалгын төрөл	Кабелийн гаргалгатай
	Суурьлуулалтын төрөл	Шалан дээр
	Ашиглах зориулалт	Суурин
	Хамгаалалтын зэрэглэл	IP54
Үзүүлэлт	Хаалганы төрөл	Шилэн / Төмөр
	Сүлжээний фазын тоо	3 фаз
	Давтамж	50hz
	U хэвийн хүчдэл	400/230V
	I Нам хүчдэлийн хэвийн A	16-630A
	P хэвийн чадал	40-400кВт
	Эзлэх модуль	42М
	Ici богино залгааны таслах гүйдлийн хязгаар	25-40кА
	Автомат таслуурын төрөл	MCB; MCCB
	Зузаан	500мм
	Өргөн	1150мм
	Өндөр	1620мм, 1820мм, 2020мм, 2220мм
	Өнгө	RAL 9003 /сонголтоор/
	Материал	1-3мм цайрдсан ган лист
	Цоожны систем	2 цэгийн цоожлолт
	Хаалга онгойх градус	180°
Нэмэлт	Стандарт	ISO9001:2015, MNS 5834:2008
	Сертификат	ТГНУБД0001631
	Ашиглалтын орчны агаарын температур	-50*С...+50*С
	Харьцангуй чийгшил	0...95%
	Хадгалах орчны агаарын температур	-40*С...+50*С

PC.DL бүтээгдэхүүний онцлог талууд



- ССА буюу хөнгөрүүлсэн зэс шин дамжуулагчтай
- Галд тэсвэртэй кабель утсаар монтажилсан
- Хэмжүүрийн хэсгийг гадны нөлөөллөөс хамгаалсан шийдэлтэй
- Самбарыг 1-3мм зузаантай цайрдсан ган төмөр листээр үйлдвэрлэсэн
- Гүйдэл хөндийрүүлэх чадвартай, хүний биед хоргүй хуурай будгаар бүрсэн
- 2 цэгийн цоожны системээр түгжигддэг хаалгатай
- Ашиглалт болон үйлчилгээ хийх үед аюулгүй байдлыг хангаж 180° дэлгэгддэг хаалгатай
- Интерьер дизайнд тохирсон өнгө загварын сонголттой
- Хаалганы дотор талд давхар модулийн хаалттай
- Амперметр, вольтметр зэрэг хэмждэг электрон хэмжүүртэй

Оруулгын бүтэц:

- Оруулгын кабель холбогдох зай /модуль/
- Сэлгэн залгагч
- Холболтын шин
- Гал хамгаалагч /автомат/
- Уян шин

Гаргалгын бүтэц:



- MCB, MCCB автомат таслуур
- Холболтын утас
- Гаралтын клем гэсэн хялбар зохион байгуулалттай
- Нэмэлтээр соронзон залгуур, дулааны реле суурилуулахад зориулсан суурийг нэмж захиалах боломжтой.



630A автомат сэлгэн залгагч /ABP/ эсвэл гаралтыг нэмэх тохиолдолд кабелийн каналтай загварыг сонгох шаардлагатай. Ингэснээр хайрцгийн хэмжээнд өөрчлөлт орж нэмэгдэнэ.

Хаалгыг 1-3мм зузаантай цайрдсан ган төмөр листээр хийдэг ба хаалганы хатуулга хийцүүдийг илүү бат бөх найдвартай болгохын тулд нэмэлт хийцээр хүчитгэсэнээр деформаци хувиралд орохгүй.

1 болон 3 цэгийн цоожны системээр түгжигддэг ба хаалганы 180* онгойлт нь ашиглалт болон үйлчилгээ хийх үед аюулгүй байдлыг хангаж, хүний хөдөлгөөнд саад болохгүй давуу талуудтай.



Битүү төмөр хаалга: Бүх төрлийн хуваарилах самбарт зохицно.


Тунгалаг шилэн хаалга: Бүх хуваарилах самбарт тохирдог. Ганжуулсан хатуулагтай, нягтаршуулсан шилээр хийдэг.

Хяналтын гэрэлтэй хаалга: Хүчдэл хянах зориулалттай.



Электрон хэмжүүртэй хаалга: Хэрэглээгээ хянах зориулалттай.



Схем зураг




Хэмжээст зураг








Схем зураг




Хэмжээст зураг






Схем зураг






Схем зураг




Хэмжээст зураг



Их бие

Канал

Төмөр хаалгатай загвар



Их бие



Канал

Шилэн хаалгатай загвар





ProCube.DL загварт зориулан ProCube.D-BS суурийг зохион бүтээж үйлдвэрлэсэн. Суурины 4 тал болон доод хэсэгт оролт, гаралтын кабель орох зориулалттай.



Тус суурийг цайрдсан ган төмрөөр хийж, гүйдэл хөндийрүүлэх чадвартай хүний биед хор нөлөөгүй хуурай будгаар будаж гагнадаг бөгөөд өргөж зөөвөрлөх ажиллагааг хялбаршуулсан хийцтэй.



Суурийн төрөл	Өндөр (H)	Өргөн (W)	Зузаан (D)
PC.DBS-400x100	100	400	500
PC.DBS-400x200	200	400	500
PC.DBS-400x300	300	400	500
PC.DBS-400x400	400	400	500
PC.DBS-400x500	500	400	500




Суурийн төрөл	Өндөр (H)	Өргөн (W)	Зузаан (D)
PC.DBS-800x100	100	800	500
PC.DBS-800x100	200	800	500
PC.DBS-800x100	300	800	500
PC.DBS-800x100	400	800	500
PC.DBS-800x100	500	800	500




Тоноглолын код	Өндөр (H)	Өргөн (W)	Зузаан (D)
PC.DBS-800x100	100	1100	500
PC.DBS-800x100	200	1100	500
PC.DBS-800x100	300	1100	500
PC.DBS-800x100	400	1100	500
PC.DBS-800x100	500	1100	500


Хэмжүүрийн схем



Тоолуурын схем



Хэмжүүр болон тоолуурын схем




ProCube.DM

Хуваарилах самбар



БҮТЭЦ



**WE BUILD
YOUR SAFETY**



Оруулгын бүтэц:

- Оруулгын ерөнхий автомат
- Кабелийн монтаж
- 16А-250А гүйдэл даах чадвартай хөнгөрүүлсэн зэс шин
- Тоолуур, гүйдлийн трансформатор нэмэлтээр суурилуулах боломжтой

Гаргалгын бүтэц:

- Гаралтын MCB, MCCB автомат таслуур
- Кабелийн монтаж
- Соронзон залгуур, дулааны реле нэмэлтээр суурилуулах боломжтой

ProCube.DM /PC.DM/ загварын хайрцаг нь хуваарилах самбар, гэрэлтүүлгийн төхөөрөмжийн самбарын зориулалтаар үйлдвэрлэгддэг бөгөөд барилгын интерьер загварт тохируулж өнгө загварын сонголт, ил болон далд суурилуулах боломжтой, IP54 хамгаалалтыг бүрэн хангасан давуу талтай юм.

PC.DM загвар нь модуль системийн аргаар угсрагдаж, шугамын холболтын төрлүүд нь босоо хэлхээнд холбогддог. Мөн гаралтын хэсгийн орон зай их, автомат гаралтыг клемтэй хийж өгснөөр холболт хийх үйл явцыг илүү хялбар, аюулгүй байдлаар шийдвэрлэсэн.

Хайрцагт нэмэлтээр хэмжих хэрэгслүүдийг суурилуулж болохоос гадна хэмжүүр тоолуурын хэлхээний гүйдлийн трансформаторыг тус тусад нь холбох зориулалт бүхий холболтыг цогцоор шийдвэрлэсэн. Хайрцагт электрон хэмжүүрийг тавьснаар загвар хийц болон ашиглалт талаас илүү хялбар бөгөөд цогц шийдэл болсон.

Модулийн давхар хаалттай бөгөөд гадаа суурилуулах зориулалттай дээвэр болон суурьтай тусгай загвараар үйлдвэрлэх боломжтой.

Техникийн үзүүлэлт

Ерөнхий

Бүтээгдэхүүний төрөл	Барилгын дотор хангамжийн хувиарлах самбар
Бүрэлдэхүүн хэсгийн төрөл	ProCube
Бүтээгдэхүүний богино нэр	PC.DM
Бүтээгдэхүүний ашиглах хүрээ	Бүх төрлийн барилга байгууламж, үйлдвэр
Оруулгын төрөл	Кабелийн оруулгатай
Гаргалгын төрөл	Кабелийн гаргалгатай
Суурьлуулатын төрөл	Шалан дээр
Ашиглах зориулалт	Суурин
Хамгаалалтын зэрэглэл	IP54
Хаалганы төрөл	Шилэн / Төмөр

Үзүүлэлт

Сүлжээний фазын тоо	3-4 фаз
Давтамж	50hz
U хэвийн хүчдэл	400/230В
I Нам хүчдэлийн хэвийн А	16-250А
P хэвийн чадал	10-150кВт
Эзлэх модул	32М
Ici богино залгааны таслах гүйдлийн хязгаар	4.5-40кА
Автомат таслуурын төрөл	MCB; MCCB
Зузаан	230мм – 430мм
Өргөн	650мм, 654мм
Өндөр	850мм - 1720мм
Жин	кг
Өнгө	RAL 9003 /сонголтоор/
Материал	1-3мм цайрдсан ган лист
Цоожны систем	3 цэгийн цоожлолт
Хаалга онгойх градус	180°

Нэмэлт

Стандарт	ISO9001:2015, MNS 5834:2008
Сертификат	ТГ№УБД0001631
Ашиглалтын орчны агаарын температур	-50*С...+50*С
Харьцангуй чийгшил	0...95%
Хадгалах орчны агаарын температур	-40*С...+50*С



PC.DM-160



PC.DM-140



PC.DM-120




PC.DM-100




PC.DM-80


Ил суух загвар



Бүтээгдэхүүний төрөл	Өндөр (H)	Өргөн (W)	Зузаан (D)
PC.DMW0-80	850	650	230
PC.DMW0-100	1050	650	230
PC.DMW0-120	1250	650	230
PC.DMW0-140	1450	650	275
PC.DMW0-140	1450	650	430
PC.DMW0-160	1650	650	275
PC.DMW0-160	1650	650	430




Далд суух загвар




Бүтээгдэхүүний төрөл	Өндөр (H)	Өргөн (W)	Зузаан (D)
PC.DMWF-80	920	654	192
PC.DMWF-100	1120	654	192
PC.DMWF-120	1320	654	192
PC.DMWF-140	1520	654	192
PC.DMWF-160	1720	654	192

ProCube.DM-80 Схем зыгар




Circuit & contactor marks	Release rated current	Phase NO.	Voltage (V)	Remarks
BA105-3P-040A-C 10kA	40A	L1,L2,L3,N	400V	-----
BA105-3P-032A-C 10kA	32A	L1,L2,L3,N	400V	-----
BA105-3P-032A-C 10kA	32A	L1,L2,L3,N	400V	-----
BA101-1P-025A-C 4.5kA	25A	L N	230V	-----
BA101-1P-025A-C 4.5kA	25A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----

ProCube.DM-120 Схем зыгар




Circuit & contactor marks	Release rated current	Phase NO.	Voltage (V)	Remarks
BA201-3P-080A-C 4.5kA	80A	L1,L2,L3,N	400V	-----
BA201-3P-080A-C 4.5kA	80A	L1,L2,L3,N	400V	-----
BA201-3P-080A-C 4.5kA	80A	L1,L2,L3,N	400V	-----
ДИФ101-1N-040A-030-C-DV	40A	L N	230V	-----
ДИФ101-1N-040A-030-C-DV	40A	L N	230V	-----
ДИФ101-1N-025A-030-C-DV	25A	L N	230V	-----
ДИФ101-1N-016A-030-C-DV	16A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----

ProCube.DM-100 Схем зыгар




Circuit & contactor marks	Release rated current	Phase NO.	Voltage (V)	Remarks
BA201-3P-080A-C 10kA	80A	L1,L2,L3,N	400V	-----
BA201-3P-080A-C 10kA	80A	L1,L2,L3,N	400V	-----
BA201-3P-080A-C 10kA	80A	L1,L2,L3,N	400V	-----
BA105-3P-040A-C 10kA	40A	L1,L2,L3,N	400V	-----
BA105-3P-032A-C 10kA	32A	L1,L2,L3,N	400V	-----
BA105-3P-032A-C 10kA	32A	L1,L2,L3,N	400V	-----
BA105-3P-032A-C 10kA	32A	L1,L2,L3,N	400V	-----
ДИФ101-1N-040A-030-C-DV	40A	L N	230V	-----
ДИФ101-1N-040A-030-C-DV	40A	L N	230V	-----
ДИФ101-1N-025A-030-C-DV	25A	L N	230V	-----
ДИФ101-1N-016A-030-C-DV	16A	L N	230V	-----
ДИФ101-1N-016A-030-C-DV	16A	L N	230V	-----
ДИФ101-1N-016A-030-C-DV	16A	L N	230V	-----


ProCube.DM-140 Схем зыгар



Circuit & contactor marks	Release rated current	Phase NO.	Voltage (V)	Remarks
МССВ 25кА. [BA302-P-00100A]	100A	L1,L2,L3,N	400V	-----
МССВ 25кА. [BA302-P-00100A]	100A	L1,L2,L3,N	400V	-----
МССВ 25кА. [BA302-P-0080A]	80A	L1,L2,L3,N	400V	-----
ДИФ101-1N-040A-030-C-DV	40A	L N	230V	-----
ДИФ101-1N-040A-030-C-DV	40A	L N	230V	-----
ДИФ101-1N-025A-030-C-DV	25A	L N	230V	-----
ДИФ101-1N-016A-030-C-DV	16A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----
BA101-1P-016A-C 4.5kA	16A	L N	230V	-----

ProCube.DM-160 Схем з'япар








Хаалга: 1-3мм зузаантай цайрдсан ган төмөр листээр хийдэг ба хаалганы хатуулга хийцүүдийг илүү бат бөх найдвартай болгохын тулд нэмэлт хийцээр хүчитгэсэнээр деформаци хувиралд орохгүй.

- 1 болон 3 цэгийн цоожны системээр түгжигддэг ба хаалганы 180° онгойлт нь ашиглалт болон техник үйлчилгээ хийх үед аюулгүй байдлыг хангаж, хүний хөдөлгөөнд саад болдоггүй давуу талуудтай.
- Хуваарилах самбарын дотор төхөөрөмжийг харахад зориулагдсан тунгалаг нягтаршуулсан шилэн болон нэмэлт тоноглолтой битүү хаалгануудаас сонгох боломжтой.

Тоноглолгүй хаалга




Шилэн хаалга




Суурь: 100-400мм өндрийн хэмжээтэй сууринаас сонгож захиалах боломжтой. Суурины 4 тал болон доод хэсэгт оролт, гаралтын кабель орох зориулалттай. Цайрдсан ган төмрөөр хийж, гүйдэл тусгаарлах чадвартай хуурай будгаар будаж, гагнадаг. Өргөж зөөвөрлөх ажиллагааг хялбаршуулсан хийцтэй

Дээд тал




3-н хэмжээстээр харагдах байдал



Урд тал



Хажуу тал



W



D

ProCube.DA

Автомат сэлгэн залгагчтай самбар



БҮТЭЦ



**WE BUILD
YOUR SAFETY**



ProCube.DA /PC.DA/ загвар нь 100-630А автомат сэлгэн залгагч суурилуулж барилгын цахилгааны тэжээл доголдох боломжгүй хамгийн чухал төхөөрөмжүүдийг гэмтлийн үед сэлгэх зориулалттай самбар юм.


Тус самбарт Schneider Electric компанийн Dekraft брэндийн автомат сэлгэн залгагч суурилуулан ССА буюу зэс бүрмэл шин, галын А үнэлгээтэй хайлдаггүй кабелиар холболт хийж аюулгүй найдвартай ажиллагааг хангасан. Мөн зэвэрдэггүй төмөр листээр хайрцаг болон модулийн хаалтыг үйлдвэрлэн өндөр хүчдэлийн туршилтын лабораторид туршиж үйлдвэрт ашиглалтад оруулдагаараа онцлогтой.

ProCube.DA Автомат сэлгэн залгагчтай самбар нь барилгын хананд ил суух зориулалттай бөгөөд IP-54 хамгаалалтын зэрэгтэй. Хаалгыг 1-3мм зузаантай цайрдсан ган төмөр листээр үйлдвэрлэдэг.

Техникийн үзүүлэлт


Ерөнхий	Бүтээгдэхүүний төрөл	Барилгын дотор хангамжийн автомат сэлгэн таслуурын самбар
	Бүрэлдэхүүн хэсгийн төрөл	ProCube
	Бүтээгдэхүүний богино нэр	PC.DA
	Бүтээгдэхүүний ашиглах хүрээ	Бүх төрлийн барилга байгууламж, үйлдвэр
	Оруулгын төрөл	Кабелийн оруулгатай
	Гаргалгын төрөл	Кабелийн гаргалгатай
	Суурьлуулалтын төрөл	Хананд
	Ашиглах зориулалт	Суурин
	Хамгаалалтын зэрэглэл	IP54
	Хаалганы төрөл	Төмөр
Үзүүлэлт	Сүлжээний фазын тоо	3 фаз
	Давтамж	50hz
	U хэвийн хүчдэл	400В
	I Нам хүчдэлийн хэвийн А	250А, 400А, 630А
	Ici богино залгааны таслах гүйдлийн хязгаар	50кА
	Сэлгэн залгалтын хяналтын хүчдэл	220В
	Сэлгэн залгалтын төрөл	Автомат/Гар
	Зузаан	275мм, 325мм
	Өргөн	800мм, 900мм, 997мм
	Өндөр	1150мм, 1300мм
	Өнгө	RAL 9003 /сонголтоор/
	Материал	1-3мм цайрдсан ган лист
	Цоожны систем	3 цэгийн цоожлолт
Нэмэлт	Хаалга онгойх градус	180°
	Стандарт	ISO9001:2015, MNS 5834:2008
	Сертификат	ТГ№УБД0001631
	Ашиглалтын орчны агаарын температур	-50*С...+50*С
	Харьцангуй чийгшил	0...95%
	Хадгалах орчны агаарын температур	-40*С...+50*С

Хэмжээст зураг



Бүтээгдэхүүний төрөл	Өндөр (H)	Өргөн (W)	Зузаан (D)
PC.DA-250	1150	800	275
PC.DA-400	1300	900	325
PC.DA-630	1300	997	325

Схем зураг




ProCube.DS

Гэрэлтүүлгийн самбар



БҮТЭЦ



**WE BUILD
YOUR SAFETY**



ProCube.DS /PC.DS/ загвар нь бүх төрлийн барилгад гэрэлтүүлгийн самбар, ослын гэрэлтүүлгийн самбар болон хуваарилах самбарын зориулалтаар ашигладаг. Хэрэглэгчийн хүсэлтээр 18P, 36P, 54P -ийн MCB загварын автомат таслуураар тоноглож, модулийн хаалттай, хананд ил болон далд хэлбэрээр суурилуулах зориулалтаар, клемтэй ,клемгүй нийт 12 төрлөөр үйлдвэрлэж байна.

Захиалагчийн хүсэлтээр барилгын хийц загварт тохируулан өнгө будгийг хослуулах боломжтой төдийгүй овор хэмжээ бага авсаархан хийцтэй самбар юм.

Техникийн үзүүлэлт


Ерөнхий	Бүтээгдэхүүний төрөл	Барилгын дотор хангамжийн хувиарлах самбар
	Бүрэлдэхүүн хэсгийн төрөл	ProCube
	Бүтээгдэхүүний богино нэр	PC.DS
	Бүтээгдэхүүний ашиглах хүрээ	Бүх төрлийн барилга байгууламж, үйлдвэр
	Оруулгын төрөл	Кабелийн оруулгатай
	Гаргалгын төрөл	Кабелийн гаргалгатай
	Суурьлуулалтын төрөл	Хананд
	Ашиглах зориулалт	Суурин
	Хамгаалалтын зэрэглэл	IP42
	Хаалганы төрөл	Төмөр
Үзүүлэлт	Сүлжээний фазын тоо	3-4 фаз
	Давтамж	50hz
	U хэвийн хүчдэл	400/230В
	I Нам хүчдэлийн хэвийн А	16-125А
	P хэвийн чадал	9-72кВт
	Эзлэх P	18P, 36P, 54P
	Iси богино залгааны таслах гүйдлийн хязгаар	4.5-10кА
	Автомат таслуурын төрөл	MCB
	Зузаан	170мм
	Өргөн	135мм - 500мм
	Өндөр	445мм - 800мм
	Өнгө	RAL 9003 /сонголтоор/
	Материал	1-3мм цайрдсан ган лист
	Цоожны систем	1 цэгийн цоожлолт
	Хаалга онгойх градус	120°
Нэмэлт	Стандарт	ISO9001:2015, MNS 5834:2008
	Сертификат	ТГН№УБД0001631
	Ашиглалтын орчны агаарын температур	-50*С...+50*С
	Харьцангуй чийгшил	0...95%
	Хадгалах орчны агаарын температур	-40*С...+50*С




Тус самбарт зөвхөн 54 фазын MCB загварын автомат таслуураар тоноглож хананд тусгай зориулалтын тогтоогчийн тусламжтайгаар суурилуулна.

- ProCube.DS-W0-54K /ил суурилуулах клемтэй загвар/
- ProCube.DS-W0-54 /ил суурилуулах клемгүй загвар/
- ProCube.DS-WF-54K /далд суурилуулах клемтэй загвар/
- ProCube.DS-WF-54 /далд суурилуулах клемгүй загвар/


Схем зураг




PC.DS-W0-54K Гаралтын клемтэй хувилбар




PC.DS-W0-54 Гаралтын клемгүй хувилбар



PC.DS-WF-54K Гаралтын клемтэй хувилбар



PC.DS-WF-54 Гаралтын клемгүй хувилбар







Тус самбарт зөвхөн 36 фазын MCB загварын автомат таслуураар тоноглож хананд тусгай зориулалтын тогтоогчийн тусламжтайгаар суурилуулна.

- ProCube.DS-W0-36K /ил суурилуулах клемтэй загвар/
- ProCube.DS-W0-36 /ил суурилуулах клемгүй загвар/
- ProCube.DS-WF-36K /далд суурилуулах клемтэй загвар/
- ProCube.DS-WF-36s /далд суурилуулах клемгүй загвар/


Схем зураг




PC.DS-W0-36K Гаралтын клемтэй хувилбар




PC.DS-W0-36 Гаралтын клемгүй хувилбар




PC.DS-WF-36K Гаралтын клемтэй хувилбар



PC.DS-WF-36 Гаралтын клемгүй хувилбар








Тус самбарт зөвхөн 18 фазын MCB загварын автомат таслуураар тоноглож хананд тусгай зориулалтын тогтоогчийн тусламжтайгаар суурилуулна.

- ProCube.DS-W0-18K /ил суурилуулах клемтэй загвар/
- ProCube.DS-W0-18 /ил суурилуулах клемгүй загвар/
- ProCube.DS-WF-18K /далд суурилуулах клемтэй загвар/
- ProCube.DS-WF-18s /далд суурилуулах клемгүй загвар/


Схем зураг




PC.DS-W0-18K Гаралтын клемтэй хувилбар




PC.DS-W0-18 Гаралтын клемгүй хувилбар



PC.DS-WF-18K Гаралтын клемтэй хувилбар



PC.DS-WF-18 Гаралтын клемгүй хувилбар





ProCube.WH

Давхрын тоолуурын самбар



БҮТЭЦ



**WE BUILD
YOUR SAFETY**



ProCube.WH загвар нь 2-6 ширхэг тоолуур суух зориулалттай барилгын давхрын самбар бөгөөд тоолуурын болон холбооны гэсэн үндсэн 2 хэсгээс бүрддэг.

Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагын дагуу 4 төрлөөр монтажлан нийлүүлнэ.


- Толгой автомат + Гаралтын энгийн автомат
- Толгой автомат + Гаралтын дифференциал автомат
- Толгой автомат + Ачаалал таслагч + Гаралтын энгийн автомат
- Толгой автомат + Ачаалал таслагч + Гаралтын дифференциал автомат

Дотооддоо үйлдвэрлэж байгаа давуу талын хүрээнд барилга угсралтын компаниудад зориулан давхрын самбараа карказ, тоноглол, жааз гэсэн 3н хэсгээр тус тусад нь салгаж барилгын үйл явцад нь тохируулан хэсэгчилж нийлүүлдэг онцлогтой. Энэхүү хэсэгчилж нийлүүлэх процесс нь барилга угсралтын компаниудын үйл ажиллагааг хөнгөвчилсөн, эрсдэлээс хамгаалсан шийдэл болсон.


Ерөнхий	Бүтээгдэхүүний төрөл	Барилгын дотор хангамжийн давхарын тоолууртай самбар
	Бүрэлдэхүүн хэсгийн төрөл	ProCube
	Бүтээгдэхүүний богино нэр	PC.WH
	Бүтээгдэхүүний ашиглах хүрээ	Бүх төрлийн барилга байгууламж, үйлдвэр
	Оруулгын төрөл	Кабелийн оруулгатай
	Гаргалгын төрөл	Кабелийн гаргалгатай
	Ашиглах зориулалт	Суурин
	Хамгаалалтын зэрэглэл	IP43
Үзүүлэлт	Сүлжээний фазын тоо	3 фаз
	Давтамж	50hz
	U хэвийн хүчдэл	400/230В
	I Нам хүчдэлийн хэвийн А	16-125А
	Гаргалга	PC.WH 4.5кА энгийн автомат
	Тоолуур	2-6 тоолуур суух боломжтой
	Ici богино залгааны таслах гүйдлийн хязгаар	4.5-10кА
	Зузаан	Жааз-160мм Каркац-130мм
	Өргөн	Жааз-950мм Каркац-860мм
	Өндөр	Жааз-975мм Каркац-920мм
Нэмэлт	Стандарт	ISO9001:2015, MNS 5834:2008
	Ашиглалтын орчны агаарын температур	-50*С...+50*С
	Хадгалах орчны агаарын температур	-40*С...+50*С




Хэмжээст зураг




Схем зураг




Хэмжээст зураг




Схем зураг




Хэмжээст зураг




Схем зураг



Хэмжээст зураг




Схем зураг







ProCube.H-B


Айлын цахилгааны самбар



БҮТЭЦ



**WE BUILD
YOUR SAFETY**




ProCube.HB загвар нь 12P, 18P, 24P, 36P-ийн автомат таслуур суурилуулах багтаамжтай айлын цахилгааны самбар юм. Тус загварын их бие нь хананд далд хэлбэрээр сууж, жааз хэсэг нь ил харагдах бөгөөд бат бөх материалтай, модулийн хаалттай, овор хэмжээ бага гэх мэт давуу талтай. Барилгын дотоод интерьерт тохируулан өнгө загварыг хослуулан захиалагчийн хүсэлд нийцүүлэх бүрэн боломжтой.


Ерөнхий	Бүтээгдэхүүний төрөл	Айлын цахилгааны самбар
	Бүрэлдэхүүн хэсгийн төрөл	ProCube
	Бүтээгдэхүүний богино нэр	PC.HB
	Бүтээгдэхүүний ашиглах хүрээ	Бүх төрлийн барилга байгууламж, үйлдвэр
	Оруулгын төрөл	Кабелийн оруулгатай
	Гаргалгын төрөл	Кабелийн гаргалгатай
	Ашиглах зориулалт	Суурин
	Хамгаалалтын зэрэглэл	IP34
Үзүүлэлт	Сүлжээний фазын тоо	3 фаз
	Давтамж	50hz
	U хэвийн хүчдэл	400/230V
	I Нам хүчдэлийн хэвийн A	16-125A
	Гаргалгын P	12-24P
	Ici богино залгааны таслах гүйдлийн хязгаар	4.5-10кА
	Зузаан	PC.HB-12 Жааз-105мм, Каркац-80мм
	Өргөн	PC.HB-12 Жааз-320мм, 285мм
Нэмэлт	Өндөр	PC.HB-12 Жааз-230мм, Каркац-180мм
	Стандарт	ISO9001:2015, MNS 5834:2008
	Ашиглалтын орчны агаарын температур	-50*С...+50*С
	Хадгалах орчны агаарын температур	-40*С...+50*С




Схем зураг




Хэмжээст зураг




Схем зураг




Хэмжээст зураг



Схем зураг



Хэмжээст зураг



ХӨНГӨН ЦАГААН БОЛОН ЗЭС


ХАРЬЦУУЛСАН СУЛ БА ДАВУУ ТАЛУУД

ЗЭС БА ССА ШИН


ХАРЬЦУУЛСАН СУЛ БА ДАВУУ ТАЛУУД

- Хөнгөнцагаан шин нь зэс шин-тэй харьцуулахад дамжуулах чадвар муу учир ижил хэмжээний гүйдэл гүйлгэхийн тулд илүү том хэмжээний хөнгөнцагаан ашиглах шаардлагатай болох тул тоног төхөөрөмжийн овор ихэсдэг.
- Хөнгөнцагаан шин нь агаартай маш хурдан исэлдэж, гадаргуу дээр нь цахилгаан дамжуулдаггүй нимгэн давхарга үүсдэг тул монтажийг хийхдээ хүрэлцэх гадаргууг байнга зүлгүүрдэх шаардлагатай. Зэс шин-д ийм давхарга үүсдэггүй тул гадаргуу нь цахилгааныг байнга сайн дамжуулдаг.
- Зэс шин нь хөнгөнцагаан шин-ээс 3 дахин хүнд тул тоног төхөөрөмж илүү хүнд болж өргөх, зөөх, тогтоох хийцүүдэд маш өндөр чанарын материалууд ашиглах шаардлагатай болдог.
- Зэс шин нь хөнгөнцагаан шин-ээс хатуу учир зэс шин-ийг нугалах, мушгих, цоолоход их хүч (тусгай зориулалтын багаж төхөөрөмж) шаардагддаг.
- ССА шин-ийн дамжуулах чадвар нь зэс шин-тэй адил
- ССА шин нь зэс шин-ээс 2,3 дахин хөнгөн
- ССА шин-ийн гадаргуу нь зэс учир гадаргуугийн цахилгаан дамжуулах шинж чанар нь зэстэй адил сайн, контакт халах үзэгдэл бага
- ССА шин эзлэхүүний 80%-90% нь хөнгөн цагаан учир зэс шин-ээс уян байдаг.


И шин




PE газардуулгын шин




Ерөнхий шин 250А




Ерөнхий шин 400А



Ерөнхий шин 630А





PROCUBE БРЭНДИЙН САМБАРТ СУУХ АВТОМАТЫН ТӨРЛҮҮД

DEKraft

Schneider
Electric

legrand[®]

ABB

CHNT

LS

iek



Модуль хэмжээс

ProCube брэнд нь модулийн хэмжээгээр дотоод зохион байгуулалтыг төлөвлөж, модулийн хаалтаар хэрэглэгчийг **ЦАХИЛГААН ХҮЧДЭЛД НЭРВЭГДЭХ** аюулаас 100% хамгаалсан загвар юм.

Модуль хаалт:

Модулийн хаалт нь хэрэглэгчийн аюулгүй байдлыг бүрэн хангах зориулалттай. Цахилгааны эрсдэлтэй тоноглол болон кабель утсыг бүрэн далдалсан тул хэрэглэгч зөвхөн асааж унтраах үйлдлийг хийх боломжтой.

Модуль хэмжээ:











/1 модуль нь 50мм өндөртэй тэнцдэг/
ProCube загвар нь олон улсын цахилгаан техникийн “модуль” нэгжээр хэмжигддэг. Бүтээгдэхүүний дотоод зохион байгуулалтыг төлөвлөх, найдвартай аюулгүй ажиллагааг хангахад өндөр ач холбогдолтой.

IP хамгаалалтын зэрэг

IP хамгаалах түвшин нь олон улсын стандартуудын дагуу нэг буюу хэд хэдэн механизм хэрхэн найдвартай байгааг тодорхойлдог ангиллын систем юм.

Цахилгаан төхөөрөмжүүд ихэнхдээ IP битүүмжлэлтэй байдаг. Энэ нь тоос шороо, шингэн зүйлээс хамгаалах тэсвэртэй байдал юм. IP битүүмжлэл нь 1000В хувьсах гүйдэл ба 1200В тогтмол гүйдэл хүртэлх энклоузер болон цахилгаан хуваарилах төхөөрөмжид зориулагдсан олон улсын стандарт түвшин бүхий код юм.

Битүүмжлэлийн код ерөнхийдөө 2 дугаартай (IP56) бөгөөд энэ нь тухайн бүтээгдэхүүний бохирдол, шингэн зүйлээс хэрхэн хамгаалахыг хэлж өгдөг. Дугаар бүр нь байгалийн хүчин зүйлсийн эсрэг хамгаалалтын зэргийг харуулдаг. 1-р тоо нь тоос шороо нэвтрэх, 2-р тоо нь шингэн зүйлийн нэвтрэх байдлыг заана. Тоонуудын утгыг дараах хүснэгтэд үзүүлээ.

0		0 - хамгаалалт байхгүй.Зөвшөөрөгдөх хэрэглээ: хуурай өрөө тасалгаанд	5		5 - усны урсгалаас хамгаалагдсан. Зөвшөөрөгдөх хэрэглээ: дундаж усны урсгалаар угаагдах газрууд.
1		1 - Чанх дээрээс дусалж байгаа дуслуудаас хамгаалагдсан. Зөвшөөрөгдөх хэрэглээ: босоо тэнхлэгийн дагуу суурьлагдсан тоноглолтой чийгтэй өрөө, тасалгаанд	6		6 - хүчтэй усны урсгалаас хамгаалагдсан. Зөвшөөрөгдөх хэрэглээ: хүчтэй усны урсгалаар угаагдах газрууд
2		2 - 15°налуутай дуслаж байгаа усны дуслуудаас хамгаалагдсан. Зөвшөөрөгдөх хэрэглээ: чийгтэй өрөө тасалгаанд,	7		7 - Төхөөрөмж нь 1 м хүртэлх гүнтэй усны даралтыг тэсвэрлэх чадвартай. усанд түр зуур шумбагдахаас хамгаалагдсан. Зөвшөөрөгдөх хэрэглээ: түр зуур усаар бүрхэгдэх эсвэл цасан доор удаан байрлах газрууд
3		3 - 60°налуутай унаж байгаа усны дуслуудаас хамгаалагдсан. Зөвшөөрөгдөх хэрэглээ: бороотой газрууд	8		8 - төхөөрөмж дор хаяж 30 минутын турш 1 метрээс илүү гүнтэй усан дор ажилладаг. Удаан хугацааны турш усанд шумбагдахаас хамгаалагдсан
4		4 - усны цацралт болон шүршдэсээс хамгаалагдсан. Зөвшөөрөгдөх хэрэглээ: бороотой болон усны цацралттай газрууд	9		9 - удаан хугацааны турш даралттай усанд шумбагдахаас хамгаалагдсан. Зөвшөөрөгдөх хэрэглээ: усанд доор шумбалтын горимд ажиллах газрууд


1	Ip44	Ip44 зэрэглэл бүхий бүтээгдэхүүн нь 1 мм-ээс их хэмжээтэй хатуу биетүүд болон бүх талаас ус цацахаас хамгаалагдсан гэсэн үг юм.	1	Ip55	Ip55 зэрэглэлийн бүтээгдэхүүн нь бүтээгдэхүүний хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй тоосжилтоос хамгаалагдсан боловч тоосжилтыг бүрэн нэвтрүүлдэггүй. Энэ нь ямар ч чиглэлээс цорго (6.3мм) тусах хатуу биет болон усны урсгалаас хамгаалагдсан.
2	Ip54	Ip54 зэрэглэл бүхий бүтээгдэхүүн нь тоосжилтоос хамгаалагдсан бөгөөд тухайн бүтээгдэхүүнийг хэвийн ажиллахаас сэргийлдэг боловч тоос нэвтрэгддэггүй. Бүтээгдэхүүн нь ямар ч өнцгөөс хатуу зүйл болон ус цацахаас бүрэн хамгаалагдсан.	2	Ip65	Хэрэв та бүтээгдэхүүн дээр IP65 гэж бичсэнийг харвал энэ нь тоос шорооноос бүрэн хамгаалагдсан бөгөөд хатуу зүйлээс хамгаалагдсан гэсэн үг юм. Дээрээс нь цорго (6.3мм) ямар ч өнцгөөс тусах усны урсгалаас хамгаалагдсан.



КАБЕЛЬ

ОХУ-ын стандартын шаардлага хангасан Кам кабель үйлдвэрийн “ПуГВнг(А)-LS 1*4” цахилгааны утсаар найдвартай, баталгаат монтажийг хийдэг.
ПуГВнг(А)-LS 1*4 утас нь эрчим хүчний салбарын томоохон компаниудад таашаагдсан, эрэлт сайтай бүтээгдэхүүн юм.

Кабелийн хамгаалалт




- Кабелийн хоолой
- Кабелийн бүрээс
- Кабель сүвлэгч
- Ирмэг дарагч
- Кабель хамгаалах резин
- Кабель далдлагч
- Кабель утасны төгсгөвч
- Кабель баригч
- Дундын болон төгсгөлийн муфт

Давуу чанар

- Галын аюулгүй байдлын индексийн А үнэлгээтэй
- Ашиглалтын хугацаа хамгийн багадаа 20 жил
- Ашиглалтын температур -40-өөс +65 градус
- Суурилуулах хамгийн бага температур -15C
- Урт хугацааны зөвшөөрөгдөх халаалтын температур 70C байна.
- 450 вольт хүртэл давтамжтай, 400 герц хүртэл давтамжтай сүлжээнд суурилуулна.



Ирээдүйд системийн өөрчлөлт хийхэд илүү хялбар байлгахын тулд холбогдох бүх баримт бичгийг /гэрэл зургийг, график гэх мэт/ самбараас ойр аюулгүй газар байлгах нь зүйтэй.



- Хаалгыг зориулалтын түлхүүрээр онгойлгох бөгөөд түлхүүр нь эрх бүхий хүнд байна.
- Хаалгыг онгойлгосноор самбарын тоноглолтой хэсэгт нэвтэрнэ.
- Хүчдэлийг тасалж залгах үйлдлүүдийг хийх боломжтой.
- Хүчдэлд залгаатай үед самбарын модулийн хаалтыг авах онгорхой орхихыг хориглоно.
- Хаалгыг зориулалтын бус түлхүүрээр онгойлгох, юм түшүүлж тавих, хаалганы хөдөлгөөнд саад учруулах, онгорхой орхихыг хориглоно.




- Энэ хэсэгт гаргалгын клем болон N, PE шин мөн хэрэглэгчийн тоолуур багтсан байдаг. Үүгээр оруулга болон гаргалгын кабелиа оруулж холбоно. Зурагт заасан байгаа боолтыг PH2 маркын отверткаар онгойлгоно.


Анхааруулга:

- Хүчдэлд залгагдсан үед кабель утас, шин зэрэгт хүрэхийг хориглоно.
- Хаалгыг онгорхой орхихыг хориглоно.
- Эрх бүхий ажилтан нэвтэрнэ.
- Самбарыг налуулж ямар нэгэн зүйл тавихыг хориглоно.
- Самбарын дээр гарж зогсох эсхүл ачаа бараа хураахыг хориглоно.


Хуваарилах самбарын багаж хэрэгслийн бариул, хэмжүүр болон тоолуурын хуваарь ба заалт нь шалнаас 1-1,8м-ийн өндөрт суурилуулсан байх ёстой. /хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүсийн өмнө – шалнаас 1,3м-ийн зайд/



Зурагт үзүүлсний дагуу M6x16 маркийн боолтыг тайлж авч шалыг авна. Үүний дараа оруулга болон гаргалгын кабелийн диаметрт тохируулан шалыг цоолж кабелийн клантыг суулгана.




Тухайн хэсэгт газардуулга болон N шин-ийг харуулж байна.



Сууринаас нь өргөж ачиж тээвэрлэх:

- Самбарыг босоо байрлалаар тээвэрлэнэ.
- Модон дам нурууг тусгайлан бэлтгэж самбарыг бэхэлнэ. Энэ нь өргөгч машин ашиглан самбаруудыг зөөвөрлөхөд илүү хялбар болгож өгнө.
- Сэрээтэй ачааны машин ашиглан зөөвөрлөж буй самбаруудыг маш сайн бэхэлж болгоомжтой өргөж тээвэрлэнэ.
- Ачааны машинд ачсаны дараагаар тухайн машинтай хамт бүхэлд нь бэхэлж өгнө.



Дээд хэсгээс өргөж ачиж тээвэрлэх:

- Кран болон өргөгч машин ашиглаж байгаа үед самбарын зориулалтын дэгээнээс бэхэлж өргөх ёстой.
- Самбарын зориулалтын 4ш чихэнд бэхэлнэ.
- Бэхэлж өргөх дүүгүүрийн уртын хэмжээг самбарын хэмжээсийн дагуу тохируулна. Дүүгүүрийн үүсэх өнцөг нь самбарын жингээс хамаарч зурагт заасан стандарт өнцгөөс хэтрэхгүй байх ёстой.
- 1-ээс олон самбарыг хамт өргөх үед дам нуруунд заавал бэхэлсэн байх ёстой.
- Самбарыг хазайлгаж болохгүй.
- Бэхлэх 4 чихэнд /цагариганд/ ачааллыг тэнцүү хуваарилахыг анхаарах хэрэгтэй.

Цахилгаан хангамжийн бүхий л асуудлыг шийдвэрлэх мэргэшсэн зөвлөх үйлчилгээг нэг дороос зэрэг авах боломжийг бүрдүүлэн харилцагч нартай хамтран ажиллаж байна.



- Амины орон сууцны цахилгаан хангамж
- Хотхоны гадна болон дотор цахилгаан хангамж
- Үйлдвэрлэл, үйлчилгээний гадна болон дотор цахилгаан хангамж
- Бусад үйлчилгээ

Туршлагатай чадварлаг инженер, дизайнер орчин үеийн шинэлэг шийдлээр таны сэтгэлд нийцүүлэн барилгын төлөвлөлт, орон зайд тохируулж цахилгаан тоног төхөөрөмжийн зураг төслийг чанартай гүйцэтгэж байна.



Гадна дотор цахилгаан хангамжийн бүтээгдэхүүний төрөл бүрийн хийц, загвар, хэмжээний сонголтоор зөвхөн танд зориулан цор ганцыг зохион бүтээх нь бидний давуу тал юм.

Зураг төслийн шийдэл нь таны өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ, олон улсын технологийн хөгжлийн чиг хандлагад нийцэх болно.

Чадварлаг мэргэшсэн шуурхай баг баталгаат хугацааны турш тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа бүрэн хариуцахаас гадна борлуулалтын дараах цогц үйлчилгээг үзүүлж байна.




- Туршилт, тохируулга хийх
- Цахилгаан хангамжийн угсралтад үзлэг шалгалт хийх
- Ээлжит үзлэг оношилгоо, засвар үйлчилгээ
- Бусад үйлчилгээ

Цахилгаан тоног төхөөрөмж нь урт хугацааны туршид аюулгүй найдвартай ажиллагаатай байх нь бидний эрхэм үнэт зүйл юм. Баталгаат хугацаа дууссаны дараа харилцагч нартай эргэх холбоотой хамтран ажиллаж, дараах үйлчилгээг санал болгодог.



- Олон улсын стандарт хангасан чанартай сэлбэгийг үйлдвэрийн үнээр нийлүүлнэ.
- Цахилгаан хангамжийн тоног төхөөрөмжид үзлэг оношилгоо хийнэ.
- Инженерийн баг мэргэжлийн зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.
- Засвар үйлчилгээ хийж эдэлгээний хугацааг уртасгана.

Эрчим хүчний системийн тогтвортой, найдвартай ажиллагааг хангах зориулалт бүхий реле хамгаалалт нь цахилгаан системийн үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилан түгээх бүх үе шатуудад ашиглагдаж, гэмтэл саатлын үед асар богино хугацаанд автоматаар ажиллан тоног төхөөрөмж болон хүний аюулгүй байдлыг хамгаалдаг. Иймээс бид Олон улсын цахилгаан техникийн хорооноос гаргасан стандартуудад нийцүүлж бүтээгдэхүүн үйлчилгээндээ нэвтрүүлсэн.





ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

БНЦМҮ ХХК нь Монголдоо үйлчилгээний сүлжээг хөгжүүлж, мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн шуурхай үйлчилгээний баг бүрдүүлэн ажилладаг.

Шуурхай үйлчилгээний баг нь харилцагч нарын хүлээлтийг давсан үйлчилгээг үзүүлэхийг зорин ажиллаж байна.

Бид өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээ нэг бүрээ бүрэн хариуцаж, тэдгээрийн ард эхнээс нь дуустал найдвартай зогсоно.

ХУВААРИЛАХ САМБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА

Захиалагч талаас Борлуулалтын менежерт цахилгааны ажлын зураг болон материалын түүвэр өгснөөр бүтээгдэхүүний үнийн санал болон уян хатан төлбөрийн нөхцөлийг ажлын 1 хоногт хүлээн авна.

Захиалагч талын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хуваарилах самбарыг үйлдвэрлэж, үйлдвэрлэлийн явцад тогтмол мэдээллээр хангана. Хамтран ажиллах гэрээнд заасан хугацаанд нийлүүлж, суурилуулалтын ажлын зураг, зөвлөмж болон бүтээгдэхүүний дагалдах баримт бичгийн хамт хүлээлгэн өгнө.

Note:

Note:

[illegible]

We Build Your Safety



📍 Монгол улс, Улаанбаатар хот,
Багануур дүүрэг, 3 дугаар
хороо, Уурхайчдын гудамж,
БНЦМҮ-ийн байр

☎ +976 7021-0210
✉ sales@bemp.mn
🌐 www.bemp.mn